

Нидерландын Хаант Улс:

тоо баримт, тэргүүлэх салбарууд, аялал
жуулчлалын мэдээлэл бүхий товч танилцуулга.



НИДЕРЛАНД



Зураг: Ц.Хүрэлбаатар

Оршил

Энэхүү танилцуулгыг бэлтгэж та бүхэнд толилуулж байгаадаа би туйлаас баяртай байна.

Миний бие 2022 оны 2-р сараас эхлэн Монгол Улс дахь Нидерландын Хаант улсын Өргөмжит Консулаар томилогдон ажиллаж байна. Монгол Улс, Нидерландын Хаант Улсын хооронд 1972 оны 3 дугаар сарын 6-нд дипломат харилцаа тогтоосон. Талууд хоорондын харилцааг авч явах албан ёсны төлөөлөгч нар томилогдсон бөгөөд манай улсаас Брюссель дахь Монгол Улсын ЭСЯ 1992 оноос хойш Нидерландыг хавсран сууж байгаа бол Бээжин дэх Нидерландын ЭСЯ манай улсыг хавсран суудаг болно.

Монгол, Нидерланд хоёр улсын харилцаа даруухан боловч найрсаг түвшинд хөгжиж байна. Дипломат харилцаа тогтоосноос хойш манай хоёр улсын хооронд хэд хэдэн албан ёсны айлчлал, зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулагдсан. Монгол Улс, Нидерланд Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой 2022 оны 3 сарын 6-нд тохиож, ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлсэн билээ.

Нидерланд улс нь 1990 оноос хойш Монгол Улсад өрнөж буй ардчилал, шинэчлэл, хөгжлийн үйл явцыг дэмжиж ирсэн нь бидний харилцааны чухал хэсэг мөн. Тус улс нь Монгол Улсад хүний эрх, ардчиллын үнэт зүйлсийг хамгаалах, зах зээлийн эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлсээр байгаа бөгөөд цаашид холбогдох салбаруудад эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр бид боломжуудыг эрэлхийлэн ажиллаж байна.

Энэхүү товхимол нь хөдөө аж ахуй, усны менежмент зэрэг олон салбарыг хамарсан танилцуулга болсон гэдэгт итгэлтэй байна. Мөн Нидерландад зочлох болон ажиллах талаар мэдээлэл багтсан байгааг дуулгахад таатай байна. Та манай хоёр орны нийгэм, эдийн засгийн хамтын ажиллагааны боломжуудын талаар уншиж танилцахын зэрэгцээ, Нидерланд Улсын зүгээс санал болгож буй боломжуудын талаар мэдээлэл авах болно.

Хэдийгээр Монгол, Нидерланд Улсууд нь газарзүйн хувьд алслагдмал хэдий ч бидэнд ижил төстэй олон чанар бий. Иймд, миний бие Нидерландын Хаант Улсын Өргөмжит Консулаар ажиллах хугацаандаа хоёр орны худалдаа, нийгэм, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэхийн төлөө хичээнгүйлэн ажиллах болно.

Хатагтай Бямбасүрэнгийн Дэлгэрмаа

Нидерландын Хаант Улсаас Монгол Улсад суугаа Өргөмжит Консул

Агуулга

Оршил	3
Нидерландын тухай	5
Нидерландад зочлох нь	8
Нидерланд улсад болон Нидерланд хүмүүстэй хамт бизнес хийх талаар	10
Хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүн	12
Ус	14
Эрчим хүч	16
Ухаалаг, ногоон хөгжил	18
Тогтвортой, амьдрахад ээлтэй хотууд	20
Хүний эрх	22
Нидерландад ажиллаж, амьдрах боломжууд	25
Холбоо барих	26



Нидерландын тухай

Нидерланд нь 41,500 гаруй км² газар нутагтай, түүний гуравны нэг нь далайн түвшнээс доор байрладаг онцлогтой, нийгэм, эдийн засгийн цогц асуудлуудыг шийдвэрлэх арвин туршлагатай улс юм. Түншлэл, хамтын ажиллагаа бол бидний амжилтын түлхүүр. Бид 17 сая иргэддээ цэцэглэн хөгжиж буй, амьдрах боломж дүүрэн орчныг бий болгохыг эрмэлзэн Засгийн Газар, бизнес эрхлэгчид, боловсролын институтууд болон иргэдтэйгээ нягт хамтран ажилладаг.

НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг тэргүүлэх бодлогын хүрээгээ болгосноор Нидерланд Улс нь дэлхийн маш олон хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрүүдэд идэвхтэй хамрагддаг билээ. Бид дотооддоо болон олон улсын тавцанд үг хэлэх эрх чөлөө, жендерийн эрх тэгш байдал болон хөдөлмөр, эрүүл мэндийн үйлчилгээ тэгш, шударга байх зарчмыг эрхэмлэж ирсэн түүхтэй.

Бид дэлхий даяр өсөн нэмэгдэж буй хүнс, ус, эрүүл мэнд, эрчим хүч, аюулгүй байдлын эрэлт хэрэгцээг хангах, мөн Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөг даван туулж, сэргээн босгох чиглэлээр мэдлэг, туршлагаа хуваалцах хүсэлтэй байна.

Бид илүү сайхан ирээдүйг цогцлоохын төлөө өнгөрснөөсөө суралцдаг. Бид бүхэнд урам зориг өгөх, харилцаа холбоо тогтоон ирээдүйд илүү таатай орчинд амьдрах боломжийг бүрдүүлэхийн төлөө тэргүүний, тогтвортой шийдлүүдийг бий болгохыг эрмэлздэг.



Албан ёсны нэршил:
Нидерландын Хаант Улс

Нийслэл:
Амстердам

Засаг захиргааны төв:
Гааг

Төрийн эрх барих хэлбэр:
Үндсэн хуульт хаант засаглалтай Парламентын
ардчилал (Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд)

Төрийн тэргүүн:
Виллем-Александр Хаан, Нидерланд Улсын Хаан,
Orange-Nassau-ийн Ханхүү

Засаг захиргааны бүтэц:
Хаант улс нь дөрвөн нэгжээс
бүрддэг. Нидерланд ба
Карибын тэнгис дэх гурван
нутаг дэвсгэр: Аруба,
Кюрасао болон Гэгээн
Маартен

Тусгай засаг захиргааны нэгж:
Хилийн чанад дахь
Бонэйр, Саба, Гэгээн
Эстатиус арлууд нь
Карибын гадаргын бүсэд
оршдог

Нутаг дэвсгэр:

41,543 km²

Байршил:
Баруун Европ, Герман,
Бельги улс болон Умард
тэнгистэй хиллэдэг

Мужийн тоо:

12

2023 оны байдлаарх оршин
суугчдын тоо:

17,834,013

Нидерланд Улсын Статистикын
Алба (CBS), 2023 оны 2 дугаар сар

Нидерландын Хаант Улс нь
Европын Холбоо (ЕХ)-г үүсгэн
байгуулагч гишүүд улсуудын
нэг юм.

Мөнгөн тэмдэгт:

Евро

Хэл:

Голланд, Фриз болон далайн
чанад дахь арлуудад Англи
болон Папьяменто

Нидерландын Хаант Улсад Зочлох нь

Та Нидерландын Хаант Улс руу аялах тухай бодож байна уу? Гайхамшигтай! Танд манай улсад зочлох 7 үндсэн шалтгаан, мөн та марталгүй санаж явбал зохих онцлог баримтуудыг хүргэж байна.

1. Бидний өнгөрсөн ба ирээдүй зэрэгцэн оршдог

Нидерланд Улсын тухай бодоход салхин тээрэм, алтанзул цэцэг, модон гутал зэрэг гайхалтай дүр төрх санаанд орж магадгүй. Тийм ээ, тэд бол манай түүх, соёлын нэг хэсэг юм. Гэвч өнөөдөр шинээр олж мэдэх зүйлс маш их байна! Орчин үеийн Нидерланд Улстай танилцаж, бидний соёлын өвийг шинэ өнцгөөс мэдрээрэй.

2. Унадаг дугуй таныг бүх газар аваачна

Нидерланд Улсад оршин суугчдаас нь олон тооны унадаг дугуй байдаг гэдгийг та мэдэх үү? Олон тооны унадаг дугуйн зам, түүний сүлжээ нь жуулчдад энэхүү аюулгүй, тогтвортой тээврийн хэрэгслийг ашиглан манай улстай танилцах боломжийг олгодог. Унадаг дугуй нь эрх чөлөө, таашаалыг илэрхийлэхийн зэрэгцээ, түүнчлэн залуучууд болон өндөр настанд байгаль орчинд ээлтэй зорчих арга зам нь болдог. Мөн та өөрийгөө манай нутгийн хүн гэж мэдрэх хамгийн оновчтой арга юм.

3. Үзэсгэлэнтэй далайн эргүүд болон гайхамшигтай байгаль

Голландын далайн эрэг нь үе үеийн аялагч, жуулчдын хувьд амрах дуртай ая тухтай газар байсаар ирсэн. Байгалийн гоо үзэсгэлэн нь гайхалтай бөгөөд далайд аажмаар нийлэх элсэрхэг өргөн далайн эрэг бүхий урт эгнээ манхнууд таны анхаарлыг татна. Үүний зэрэгцээ, задгай талбай, нил яагаан тал, зэрлэг ан амьтдаар дүүрэн өргөн уудам ой мод зэрэг нь таны замын эргэлт бүрт өөр өөр өнгө үзэмжийг харуулдаг.

4. Ус бол бидний хувьд маш өвөрмөц

Нидерландын Улс нь устай салшгүй холбоотой буюу бидний судсаар ус урсдаг гэж хэлж болно. Устай харилцах харилцаа нь бидний түүхэнд чухал байр суурийг эзэлдэг бөгөөд бидэнд асар их хөгжил, цэцэглэлтийг авчирсан. Өнөө үед усны менежмент маш чухал сэдэв хэвээр байна. Ихээхэн газар нутаг нь далайн түвшнээс доор оршдог улсад амьдрахад бүтээлч байдал, ур ухаан их шаардагддаг.



Зураг: Ernst Wagensveld

5. Хараа алдрам уудам алтанзул цэцгийн талбай

Голландын түүхийн чимэг нь цэцэг, ургамал, хүнсний ногоо болон жимс, жимсгэнэ билээ. Манай улсын өвөрмөц өнгө төрхийг цэцэгжүүлэлт бүрдүүлдэг бөгөөд цэцгүүд дундаас хамгийн чухал нь алдарт алтанзул цэцэг юм. Алс, ойрын жуулчид гайхалтай тэгш газар дахь ер бусын өнгө үзэмжийг бишрэх гэж Нидерланд Улсыг зорьдог.

6. ‘Шинэ Голланд’-ын урам зориг төрүүлэм загварууд

Шинэ Голланд нь архитектур болон загварын өлгий юм. Гэвч модерн урлаг, бүжгийн үзэгдэл, загвар зохион бүтээгчид, гудамжны урлаг зэрэг нь ердийн хотын уур амьсгалыг мөн бүрдүүлдэг. Бидний чөлөөт, бүтээлч, шинийг санаачлагч сэтгэлгээ нь шинэ санаа, санаачилгыг байнга бий болгодог бөгөөд энэ нь жуулчдыг гайхшруулж, юмсыг өөр өнцгөөс харах боломжийг олгодог.

7. Голландын алдарт мастеруудтай уулзах

Бид Голландын мастеруудын бүтээл, түүхийг хүмүүст хүртээмжтэй болгож, эдгээр уран бүтээлчдийг “энгийн” Голланд хүмүүс байсан гэдгийг харуулдаг. Бид тэдний талаар маш их зүйлсийг мэддэг учир жуулчдад тэдний аж амьдралын тухай сайн ойлголт, мэдээллийг өгч чаддаг. Тухайн үеийн бүтээлд манай хотуудыг маш сайн дүрсэлсэн байдаг учраас тэдний орчин тойрон ямар байсныг төсөөлөхөд хялбар билээ.

Хэрэв та Нидерландын Хаант Улс руу аялах гэж байгаа бол манай аялал жуулчлалын талаарх зөвлөгөө байнга шинэчлэгддэг бөгөөд Нидерланд Улс руу нэвтрэхэд тавигдах шаардлага мөн авч явах боломжтой зүйлс гэх мэт практик зөвлөмжийг өгнө.

Холбооцоор шилжих: <https://www.netherlandsworldwide.nl/theme/travel>.

Нидерландын Хаант Улстай бизнес хийх, тус улсад бизнес эрхлэх

Дэлхий ертөнц хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаа энэ үед бид энх тайван, хүртээмжтэй байдал, хөгжиж буй нийгмийг бий болгоход гүйцэтгэх үүргээ эргэн харах шаардлагатай бөгөөд хамтдаа ажиллах нь урагшлах цорын ганц арга зам юм. Олон улсын хамтын ажиллагаа, түншлэлийг эрэлхийлснээр бид хүсэл тэмүүлээ нэгтгэж, бизнес, сайн үйлс зэргийг гар нийлүүлэн хийж чадахыг харуулна гэдэгт итгэлтэй байна.

1. Бизнесийн түнш олох

Та Нидерланд Улсаас бизнесийн түнш хайж байна уу? Манай Өргөмжит Консултай хамгийн түрүүнд уулзаарай. Дараах цахим шуудангаар холбогдоно уу: delgerbyambasuren@gmail.com.

2. Нидерланд Улсад хөрөнгө оруулах нь

Нидерланд Улсад бизнесээ өргөжүүлснээр та хөдөө аж ахуй, хүнс, ус, эрчим хүч, хөдөлгөөн, хот төлөвлөлт зэрэг салбаруудад ахиц дэвшил үзүүлэх инновацийн сүлжээ, төслүүд, тогтолцоонд хандах боломжтой болно. Мөн та манай тэргүүлэх зэрэглэлийн дэд бүтэц, дэлхийн түвшний олон хэлээр ярих чадвартай боловсон хүчин, бизнест ээлтэй эрх бүхий байгууллагууд зэрэг хамтран ажиллах сэтгэлгээтэй олон улсын бизнес орчны нэг хэсэг болно. Түүнчлэн Европын голлох зах зээл болон түншүүдтэй холбогдоход Нидерланд улс нь Европын гүүр болох юм.

Европт үйл ажиллагаагаа тэлэх хүсэл эрмэлзэлтэй олон улсын компаниудын хувьд юун түрүүнд Нидерланд Улсын Гадаадын Хөрөнгө Оруулалтын Агентлаг



Зураг: Ben Wind

(NFIA)-тай холбоо барих хэрэгтэй. Эдийн Засгийн Харилцаа, Уур Амьсгалын Бодлогын Яамны харьяа Нидерланд Улсын Гадаадын Хөрөнгө Оруулалтын Агентлаг нь гадаад компаниудыг Нидерланд Улсад үйл ажиллагаагаа эрхлэхэд нь чиглүүлж ажилладаг юм. www.investinholland.com холбоосоор зочилно уу.

3. Хариуцлагатай бизнесийн үйл ажиллагаа

Нидерландын Засгийн Газар бүх тохиолдолд таныг бизнесээ хариуцлагатай явуулна гэж үзнэ. Хариуцлагатай бизнесийн үйл ажиллагаа (ХБҮА) гэдэг нь та өөрийн компанийн үйл ажиллагаанд хүний эрх, ажлын байрны нөхцөл болон үйл ажиллагаа явуулах орчныг анхаарч ажиллахыг хэлнэ.

Нийлүүлэлтийн сүлжээ болон үйл ажиллагаанд учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлж, урьдчилан сэргийлэхийн тулд та ЭЗХАХБ (OECD)-ын “Хариуцлагатай бизнесийн үйл ажиллагаанд зохих хяналт шалгалтын удирдамж”-тай танилцах боломжтой: <https://mneguidelines.oecd.org/due-diligence-guidance-for-responsible-business-conduct.htm>.

Хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүн

Дэлхийн хэмжээний эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, судалгааны их сургуулиуд мөн шинжлэх ухаан, аж үйлдвэрийн салбарт төр болон хувийн хэвшлийн нягт түншлэлийг бий болгосноор Нидерланд Улс нь АНУ-ын дараа орох дэлхийн хоёр дахь том хөдөө аж ахуйн экспортлогч улс болсон.

2022 онд Нидерланд Улсын олон талт хөдөө аж ахуйн салбар нь 122.3 тэрбум евротой тэнцэх хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн экспортлосон байна. Мөн тус салбар нь газар тариалан болон сүүний аж ахуй, хүлэмжийн тариалалт, мод суулгалт болон гахайн ферм зэрэг олон талт, өргөн хүрээг хамарсан мал аж ахуй болон газар тариалангын салбаруудыг багтаадаг.

Нидерланд Улс нь НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтуудтай уялдуулан өөрийн 2030 хүртэлх үндсэн зорилгуудыг тодорхойлсон. Бид өлсгөлөн, хоол тэжээлийн дутагдлыг бууруулах дэлхийн хүчин чармайлтад дараах байдлаар хувь нэмрээ оруулахыг зорьж байна:

- өндөр чанартай, тэжээллэг хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх (SDG 2)
- дэлхий даяарх найман сая фермерийн бүтээмжийг хоёр дахин нэмэгдүүлэх (SDG 8)
- найман сая га газрыг тогтвортой менежментэд шилжүүлэх (SDG15)
- түүхий эд, хэрэглээний хариуцлагатай ашиглалтыг дэмжих (SDG 12).

Сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд Нидерланд Улс нь хөдөө аж ахуйн шинэлэг үйлдвэрлэгч гэдгээрээ олон улсад нэр хүндтэй болсон. Гэсэн хэдий ч газар тариалангийн хэтийн төлөв нь инноваци, шинэ арга барилыг нэвтрүүлэхийг шаарддаг. Нидерланд Улс нь бусад улс орнуудад байгалийн нөөц, түүхий эдийг үр ашигтай ашиглахын зэрэгцээ өсөн нэмэгдэж буй дэлхийн хүн амын хэрэгцээг хангах хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж чадна.

Нидерланд Улс нь уг салбарт хөрсний чанарыг нөхөн сэргээх, хөдөө аж ахуйн сайн туршлага, логистик, түгээлт, хэрэглэгчдийн оролцоо зэрэг сүлжээг хамарсан мэдлэг, технологиор хангах замаар чухал үүрэг гүйцэтгэж чаддаг. Нидерланд Улс нь хүнсний аюулгүй байдлын эрсдэлтэй байгаа улс орнуудад тухайн улсын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замуудыг хамтран бий болгох замаар дэмжлэг үзүүлэх боломжтой.

Илүү ихийг мэдэхэд бэлэн үү?

Хөдөө аж ахуй, тариалан болон хүлэмжийн тариалалтын ертөнцтэй танилцана уу. Бид хүнсний аюулгүй байдлыг хангахын тулд дэлхийн өнцөг булан бүрд үйл ажиллагаа явуулж буй бизнес, мэдлэгийн институт болон Засгийн Газруудтай хэрхэн хамтран ажилладаг талаар судлаарай. Ирээдүйг хамтдаа бүтээцгээе: <https://farmingthefuture.nl/>.

A man in a brown t-shirt and dark pants is working in a large, modern greenhouse. He is bent over, tending to rows of green plants in wooden planters. The greenhouse has a high ceiling with a complex metal structure and is filled with rows of plants. Numerous artificial lights, including purple and yellow ones, are hanging from the ceiling, illuminating the space. The overall atmosphere is one of advanced agricultural technology.

Farming the Future



Ус биднийг холбож, тэтгэдэг ч томоохон байгалийн гамшигийн 90 хувь нь устай холбоотой байдаг. Мөн уур амьсгалын өөрчлөлт нь хэт их, хэт бага, эсвэл бохир уснаас үүдсэн сорилтыг нэмэгдүүлж байна.

Ус, далайгаас үүдэлтэй сорилттой тэмцэх нь уур амьсгалын өөрчлөлт болон дэлхийн бусад сорилтуудыг шийдвэрлэхэд тусална. Гэвч Нидерланд Улс нь үүнийг ганцаараа хийж чадахгүй тул бид хамтдаа ажиллаж, мэдлэгээ хуваалцаж, технологийн боломжийг ашиглах хэрэгтэй. Бид хамтдаа байснаар ус, далайн усны нөөцийг тогтвортой удирдаж чадна.

Нидерланд Улсын газар зүйн байршил нь хүн ам шигүү суурьшсан, нам дор бэлчирт оршдог нь манай түүх, соёл, нийгэм болон ардчилалд нөлөөлсөн юм. Голландууд далан барьж, газар нутгаа хадгалж авч чадсанаараа дэлхийд танигдсан бөгөөд устай холбоотой асуудлыг олон зуун жилийн хугацаанд даван туулсан нь бидэнд шинэ ойлголт төрүүлсэн юм. Өнөөдөр, Нидерланд Улс нь дасан зохицох чадвартай хот, эргийн хамгаалалтыг бий болгохын тулд байгалийг өөрийг нь ашигладаг.

Усны сорилтууд биднийг хамтран ажиллах, шийдэл гаргах үйл ажиллагаанд хүн бүрийг оролцуулах,

шинэ шийдлүүдийг хилийн чанадад эрэлхийлэхийг сургасан. Үүнийг бид хэрхэн хийх вэ? Түншлэл, мэдлэг солилцох болон хамтын шинэчлэлтийн замаар хийнэ. Үүний хариуд бид дэвшилтэт усны менежмент, бэлчир, далайн технологио та бүхэнтэй хуваалцахад бэлэн байна. Усан боомтын бүтээн байгуулалт, загасчлал, усан онгоцны үйлдвэрлэл, гүний хайгуул зэрэг нь дэлхийн хамтын ажиллагааны үр шимийг хүртэх далай, тэнгисийн олон салбаруудын нэг юм. Усны нэгдсэн менежментийн хүрээнд усан хангамж, ус цэвэршүүлэх байгууламжийг сайжруулах нь нийгэмд өгөөжтэй. Саарал усны менежмент нь цэвэр усыг байгалийн эргэлтэд эргүүлэн оруулж, олон талт байдлыг сайжруулж, энэхүү үнэ цэнэтэй, хязгаарлагдмал нөөцийг бий болгодог.

Голландын Засгийн Газар нь дэлхий даяарх усыг аюулгүй, баталгаатай байлгахад хувь нэмрээ оруулах үүрэг хүлээдэг. Тиймээс, 2023 оны гуравдугаар сард Нидерландын Хаант Улс нь НҮБ-ын Усны бага хурлыг Тажикстан Улстай хамтран Нью-Йорк хотноо зохион байгуулсан. Бид дэлхийн хамтын нийгэмлэгийн бүх түншүүдийг энэхүү бага хуралд оролцож, усны аюулгүй байдлын төлөө усаа нандигнах үйл хэрэгт уриалж байна.

Эрчим хүч

Дэлхийн эрчим хүчний шилжилт нь уур амьсгалын өөрчлөлттэй амжилттай тэмцэхэд маш их үүрэг гүйцэтгэдэг. Сүүлийн үеийн геополитикийн үйл явцын өрнөл нь зөвхөн олон улсын хамтын ажиллагааны хүрээнд сэргээгдэх эрчим хүч рүү шилжих зайлшгүй шаардлагатайг нотлож байна. Нидерланд Улс нь ЕХ-ны стратегид итгэдэг бөгөөд эрчим хүчний шилжилтэд шууд нөлөөлөх системчилсэн өөрчлөлтөд хувь нэмрээ оруулах хил дамнасан түншлэл, хамтын ажиллагааг бий болгохыг эрмэлздэг.

Цэвэр болон сэргээгдэх эрчим хүч

Цэвэр эрчим хүч бол дэлхийн нийтийн сорилт болоод байна. Байгаль орчныг хамгаалах, байгальтай харьцах олон жилийн туршлага дээрээ үндэслэн Голландчууд ус асуудлыг шийдэхэд манлайлан оролцож байна. Энэ хүрээнд Голландчууд дараах чиглэлээр бусад улс орнуудад танигдсан билээ. Үүнд:

- олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, өрсөлдөх чадвартай, найдвартай, худалдан авах боломжтой, тогтвортой шийдлүүдийг бий болгох;
- мэдлэгийн солилцоог идэвхжүүлэх Засгийн Газар, их сургууль, бизнесийн хамтын хөтөлбөрийг боловсруулах (Triple Helix);
- эрчим хүчний дэвшилтэт салбар, дэд бүтцийг бий болгох;
- холбогдох сэдвээр судалгаа хийх (жишээлбэл, ECN);
- устөрөгч, салхи, нарны эрчим хүч гэх мэт чиглэлээр туршлага бий болгох.

Сэргээгдэх эх үүсвэрүүд

Эрчим хүчний үр ашигтай зарцуулалт, цахилгаан тээвэр нь Нидерландын Засгийн Газрын тэргүүлэх чиглэл юм. Голландын төмөр замууд нь сэргээгдэх эх үүсвэрээр ажилладаг цахилгаанжуулсан төмөр замын өргөн сүлжээтэй болсон. Илүү олон орон нутгийн засаг захиргаа цахилгаан болон устөрөгчийн түлшээр ажилладаг автобусны шугамыг явуулж байна. Түүнчлэн цахилгаан машины хэрэглээ нэмэгдэх хэрээр түүнийг дагасан дэд бүтэц нь өргөжин тэлж байна.

Сэргээгдэх эрчим хүч Нидерландыг ойрын жилүүдэд цахилгаан эрчим хүчний цэвэр импортлогчоос цэвэр экспортлогч орон болгох төлөвтэй байна. 2008-2018 онд сэргээгдэх нийт эрчим хүчний бүрэлдэхүүнд эзлэх хувь хоёр дахин нэмэгдсэн. Өнөөдрийн байдлаар био эрчим хүч нь сэргээгдэх эрчим хүчний үндсэн эх үүсвэр болж байна. 2030 он гэхэд салхи, нарны эрчим хүч сэргээгдэх эрчим хүчний гол эх үүсвэр болж, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн 70 хувийг бүрдүүлнэ.

Нүүрстөрөгч бага ялгаруулах эдийн засаг

Уян хатан, харилцан холбогдсон эрчим хүчний системүүд нь нүүрстөрөгчийн хий бага ялгаруулах эдийн засагт зардал багатайгаар шилжих бидний зорилгын үндэс юм. Бид олон улсын түншүүдтэй хамтран эрчим хүчний шинэ технологи дээр судалгаа хийж, хамтран ажилладаг.



Нидерландын устөрөгчийн хөндий

Нидерландын хойд бүс нутагт устөрөгчийн нэгдсэн экосистемийг үр дүнтэйгээр хөгжүүлэх онцгой боломж бүрдэж байгаа нь дэлхийн устөрөгчийн чиглэлээрх хөгжил, чиг хандлагад өөрчлөлт оруулж, эрчим хүчний шилжилтийг эрчимжүүлэх болно.

Устөрөгчийн хөндийд 4 сэдвийн хүрээнд салбар дундын хандлагад суурилан төр, хувийн хэвшлийн оролцогч талуудтай хамтран 30 гаруй дэд төслийг боловсруулан, хэрэгжүүлж байна. Агуулах ба дэд бүтэц, устөрөгчийг үйлдвэрлэлийн түүхий эд болгон боловсруулах, устөрөгчийг орон сууцны хороололд дулаан, эрчим хүч болгон ашиглах болон тогтвортой мээвэр зэрэг болно.

Европ дахь анхны устөрөгчийн хөндийд суурилан Нидерланд Улс нь устөрөгчийн эрчим хүчний шилжилт, хөгжлийг эрчимжүүлэхээс гадна үүгээрээ олон улсын хамтын нийгэмлэгт үлгэр жишээ болж чадна.



Зыпар: PAL-V

Ухаалаг, байгаль орчинд ээлтэй тээвэр

Тээврийн хүрээнд Нидерланд Улсыг бизнесийн боломжуудаар тодорхойлно. Нидерланд нь хүн ам шигүү суурьшсан улс юм. Тээвэр, байгаль орчин, аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхийн тулд шинэ технологи ашиглах нь нэн тулгамдсан асуудал болоод байна. Түүнчлэн Нидерланд Улс нь ухаалаг хөдөлгөөнт шийдлүүдийг зохион бүтээж, туршин, өргөн хүрээнд нэвтрүүлэх өвөрмөц, амьд лаборатори юм.

Цахилгаан тээвэр тоон үзүүлэлтээр

25%

нийтийн тээврийн хэрэгслийн
цахилгаан хөдөлгүүртэй

100,000+

гаруй цахилгаан автомашин
цэнэглэх цэгтэй

Голландчууд:

- ухаалаг тээвэр нь гагцхүү үндэсний эрх ашгийн дараа орох ач холбогдолтой гэдэгт бат итгэлтэй байдаг;
- энэхүү нийтлэг зорилгыг хэрэгжүүлэхийн тулд бизнес, мэдлэгийн хүрээлэн, эрх баригчид хүчээ нэгтгэх;
- хариуцлага, аюулгүй байдал, хувийн нууцтай холбоотой асуудлаар олон талт гэрээнд гарын үсэг зурсан;
- автомашин, технологи, дэвшилтэт технологийн салбарт нэр хүндтэй мэдлэгийн кластертай байх;
- дэлхийн хамгийн шилдэг дэд бүтэцтэй, далай, агаар, авто зам, төмөр замын байгууламжууд нь үргэлж тэргүүлэх байр эзэлдэг;
- бараг бүх өрхөд (98%) өндөр хурдны өргөн зурвас (хамгийн багадаа 30 Mbps) ашиглах боломжтой тул интернет холболтын хувьд 1-рт ордог;
- шинэ технологи, материалын хөгжлөөр дэлхийд тэргүүлдэг өндөр технологийн салбартай.

**Илүү урам зоригийг хайж
байна уу?**

Эдгээр тогтвортой бөгөөд хүртээмжтэй зургийг үзнэ үү:
<https://www.nlplatform.com/search?search=smart+mobility>.



Хуудас 19, 20 Тогтвортой, амьдрахад тохиромжтой хотууд:

Ухаалаг хотууд бол эцсийн цэг биш, тасралтгүй үргэлжлэх аялал юм. Гэвч хотууд маш хурдацтай өөрчлөгдөж байгаа нь 30 жилийн дараа иргэдэд юу хэрэгтэй, тэд юу хүсэхийг таахад бэрх болгож байна. Хотын тогтвортой хөгжлийг ахиулж, хүртээмжтэй, ирээдүйд нийцсэн хотуудыг бий болгох цорын ганц арга зам нь хамтран ажиллаж, бие биенээсээ суралцах явдал юм.

Дэлхийн хүн ам шигүү суурьшсан

улсуудын нэг болох Нидерланд Улс нь бүх газар нутгаа оновчтой ашиглах арга замыг үргэлж олж ирсэн бөгөөд тэр дунд үзэсгэлэнтэй архитектуртай барилгууд бий. Үүний үр дүнд нягт хамтын ажиллагаа бүхий хот суурин газруудын сүлжээ бий болж, жил бүр олон тооны зочдыг татдаг. Олон үйлдэлт дизайн, дэвшилтэт технологи, ухаалаг тээврийн хэрэгслийн ачаар Нидерландын хотууд ирээдүйн баталгаатай, уян хатан болох замдаа амжилттай явж байна.



Голландчууд дараах чиглэлээр гарамгай мэргэшсэн байдаг. Үүнд:

- Дугуй хэлбэртэй, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөгүй барилга, байгууламж
- Уур амьсгалд дасан зохицох
- Ухаалаг, байгаль орчинд ээлтэй тээвэр болон дэд бүтэц
- Ногоон хөдөө аж ахуй
- Хотын эрүүл амьдралын хэв маяг
- Эрүүл мэнд болон аюулгүй байдал
- Нэгдмэл бүтэц зохион байгуулалт бүхий дахин боловсруулах шийдэл болон тэдгээрийг хэрэгжүүлэх арга техник, технологийн ололтыг хөгжүүлэх
- Технологийн ололтын хурдацтай хөгжил бус нийгмийн сорилтыг шийдвэрлэхийг чухалчилж ажиллах.

Тогтвортой, амьдрахад тохиромжтой хотуудыг бий болгохын төлөө та юу хийдэг вэ? Бидэнтэй хуваалцана уу гэж хүсэж байна!



Хүний эрх

Нидерланд нь хууль дээдлэх засаглалтай ардчилсан улс юм. Голландын нийгмийн үндэс нь хүний эрх бөгөөд хүний нэр төр, эрх чөлөө болон хүний хөгжил нь үүний нэг хэсэг билээ. Бид олон улсад болон дотооддоо хүний эрхийг сурталчилж, хамгаалдаг баялаг уламжлалтай.

Бид дотооддоо хүний эрхийг Үндсэн хуулиараа хамгаалдаг. Тухайлбал, Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд “Нидерланд улсад ижил нөхцөл байдалд байгаа хүн бүрт ижил тэгш хандах ёстой” гэж заасан. Түүнчлэн дотоодын хууль тогтоомжоос гадна Нидерланд Улс нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалаас үүдэн бий болсон олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд нэгдэн орсон. Үндсэн хуулийн 90

дүгээр зүйлд Засгийн Газар олон улсын эрх зүйн дэг журмыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ гэж заасан байдаг. Хүний эрхийг сахин хамгаалах нь нарийн төвөгтэй ажил бөгөөд Нидерландын Засгийн газар үүнд хэрхэн хүрэхийг зорьж буйг “Хүний эрхийн үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан байдаг.

Та Нидерланд дахь хүний эрхийн бодлогын тухай илүү ихийг мэдмээр байна уу? Тэгвэл дараах холбоосоор орж үзнэ үү government.nl/topics/human-rights/human-rights-in-the-netherlands.

Нидерланд Улс хүний эрхийн талаар идэвхтэй гадаадад бодлого хэрэгжүүлдэг. Бид ЕХ, НҮБ зэрэг олон улсын байгууллагуудад хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хамгаалахаас гадна уг асуудлаар тусгайлсан Хүний эрхийн сан, Хүний эрхийн Элчин сайдтай. Манай хүний эрхийн гадаад бодлогын хүрээнд таван чиглэлийг онцгой ач холбогдол өгдөг. Үүнд:

- **Үзэд бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө болон цахим орчин дахь эрх чөлөө.** Энэ хүрээнд Нидерландын Засгийн Газар дэлхий даяарх сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын бие даасан байр суурийг дэмждэг.
- **Шашин шүтэх болон итгэл үнэмшилтэй байх эрх.** Хүн бүр өөрийн шашин, үзэл суртлыг сонгох, мөн өөр шашинд шилжих, итгэх, үл итгэх эсэхээ шийдэх эрхтэй.
- **LGBTIQ+ хүмүүсийн эрх тэгш байдал (LGBTIQ+).** Нидерланд Улс нь дэлхийн дахинд ижил хүйстэн хүмүүсийн гэрлэлтийг хуульчилсан анхны улс бөгөөд дэлхий дахин дахь LGBTIQ+ хүмүүсийн тэгш эрхийн асуудлыг дэмждэг.
- **Эмэгтэйчүүд, охидын эрх тэгш байдал.** Нидерланд Улс нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн гэрлэлтээс урьдчилан сэргийлэх, эмэгтэйчүүдийн улс төр, эдийн засгийн оролцоог дэмжих, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудалд анхаарч ажилладаг.
- **Хүний эрхийн хамгаалагчдыг дэмжих.** Нидерландын Засгийн Газар хүний эрхийг хамгаалахыг эрэлхийлж буй хувь хүн, байгууллагыг дэмждэг бөгөөд энэ нь тэдэнд ажлаа үр дүнтэй, аюулгүй хийх боломжийг олгодог.
- **Онц ноцтой гэмт хэрэгт ял шийтгэлгүй үлдэхтэй тэмцэх.** Нидерланд Улсад Олон улсын эрүүгийн шүүх (ОУЭШ) байрладаг бөгөөд тус улс ялгүйдлийн эсрэг тууштай тэмцдэг.

Хүний эрхийн чиглэлээр тодорхой үр дүнд хүрэхэд хамтын ажиллагаа чухал юм. Тийм ч учраас Нидерланд Улс нь хүний эрхийн тэргүүлэх зургаан чиглэлд орон нутгийн түншлэлийг эрэлхийлдэг. Хэрэв та Нидерландын хүний эрхийн бодлогын талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл, дэлгэрэнгүй мэдээллийг government.nl/topics/human-rights/ цахим хаягаас авна уу.



Нидерландад ажиллаж, амьдрах:

Нидерландад ажиллах

Үндэстэн дамнасан компаниуд, шинэлэг стартапууд, ажил амьдралын тэнцвэртэй байдал нь дэлхийн өнцөг булан бүрээс хүмүүсийг Нидерландад карьераа урагшлуулахад урам зориг өгдөг. Та яагаад Нидерландад очих ёстойгоо олж мэдээрэй. Нидерландад ажиллах талаар мөн ажлын байрны соёл, эрэлттэй салбаруудын тухай дэлгэрэнгүй нийтлэлүүдийг доорх холбоосоор орж уншина уу. <https://www.welcome-to-nl.nl/work-in-nl>.

Нидерландад амьдрах

Үзэсгэлэнт хотын өнгө үзэмжээс гадна Нидерландын амьдрал гэдэг нь урлаг, соёлын өргөн сонголт, олон улс орны иргэдээс бүрдсэн нийгэм, Европын бусад орнууд руу зорчиход хялбар дэд бүтэц мөн унадаг дугуйгаар чөлөөтэй аялах боломж юм. Та үүнд бэлэн үү? Эрүүл мэнд, орон сууцны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорх холбоосоор авна уу: <https://www.welcome-to-nl.nl/living-in-the-netherlands>.

Цагаачлал

Оршин суух зөвшөөрөл болон холбогдох мэдээллийг доорх холбоосоос хараарай. Нидерланд Улс нь олон улсын авъяас, чадвартай иргэдийг дэмждэг бөгөөд уг асуудлаар олон төрлийн үйлчилгээг үзүүлдэг: <https://www.welcome-to-nl.nl/immigration>.

Бид Тантай холбогдох хүсэлтэй байна!

Хатагтай Бямбасүрэнгийн Дэлгэрмаа

Нидерландын Хаант Улсаас
Монгол Улсад суугаа
Өргөмжит Консул

delgerbyambasuren@gmail.com
+976 99092836

Скай Плаза Бизнес Төв
Элчингийн гудамж 9,
СБД, хороо 1, хороолол 13,
Улаанбаатар 14220, Монгол улс

Нидерландын Хаант Улсаас Бүгд
Найрамдах Хятад Ард Улсад суугаа
Элчин Сайдын Яам

pek@minbuza.nl

Өмнөд Лианмахэ зам, 4
Чаян дүүрэг
Бээжин 100600

Шинэчлэгдсэн мэдээллийг бидний дараах цахим
холбоосоор авна уу. Цахим хуудас:

 netherlandsandyou.nl/your-country-and-the-netherlands/mongolia

 Embassy of the Kingdom of the Netherlands in Mongolia

 NLinMongolia

Нидерландын Хаант Улсаас албан ёсоор хэвлүүлэв.



